

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-13</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>14-29</i>
<hr/>	
<i>1. Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын 8 гишүүн 2024.04.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>14-14</i>
<i>2. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	<i>15-19</i>
<i>3. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал 2019.02.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>19-29</i>

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 04 дүгээр сарын 11-ний өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 01 минутад Төрийн ордны “Улсын Их Хурлын даргын уулзалт, хурлын” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Ганибал, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл,

Чөлөөтэй: Ч.Хүрэлбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Ц.Даваасүрэн, Т.Доржханд.

Нэг.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын 8 гишүүн 2024.04.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг техникийн саатал үүссэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Тогтоолын төслийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

Ц.Цэрэнпунцаг: “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал 2019.02.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн саналыг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Н.Энхболд /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, түүнд тавигдах шаардлага, мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тодорхойлох, төрийн байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбарын мэргэжлийн нэгдсэн холбоонд энэ хууль үйлчилнэ.

3.2.Мэргэжлийн холбоо болон энэ хуулийн 3.1-д зааснаас бусад салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой харилцааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулна.

3.3.Энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Төрийн бус байгууллагын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.1.“мэргэжлийн холбоо” гэж салбар, эсхүл мэргэжлийн эрх ашгийг хамгаалах зорилгоор аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, тухайн салбарын мэргэшсэн хүнээс бүрдсэн гишүүнчлэл бүхий холбоог;

4.1.2.“мэргэжлийн нэгдсэн холбоо” гэж тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодын гишүүнчлэлтэй, салбарын нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилго бүхий холбоог.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Хоёрдугаар бүлгийн гарчгийн “Мэргэжлийн нэгдсэн холбооны тогтолцоо, зохион байгуулалт, чиг үүрэг” гэснийг “Мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, түүнд тавигдах шаардлага” гэж өөрчилж, 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах, түүнд тавигдах шаардлага

5.1.Мэргэжлийн нэгдсэн холбоог тухайн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоод хамтран үүсгэн байгуулна.

5.2.Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

5.2.1.мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмийг батлах;

5.2.2.мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох;

5.2.3.мэргэжлийн нэгдсэн холбооны нэрийг батлах;

5.2.4.мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан тухай шийдвэрийг батлах.

5.3.Мэргэжлийн нэгдсэн холбоо дараах шаардлагыг хангасан байна:

5.3.1.тухайн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодын олонхын төлөөлөл бүхий гишүүнчлэлтэй байх;

5.3.2.энэ хуулийн 5.3.1-д заасан гишүүд нь тухайн салбарын зах зээл дэх үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтын тавиас дээш хувийг эзэлдэг байх.

5.4.Тухайн салбарын мэргэжлийн холбоо дангаар, эсхүл олонхын төлөөлөл бүхий гишүүнчлэлтэй бол энэ хуульд заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн бүртгүүлж, мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүргийг хэрэгжүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмэх:

“6 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлт

6.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.

6.2.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтийг Улсын дээд шүүхийн баталсан маягтын дагуу гаргаж, дараах мэдээллийг тусгах бөгөөд уг холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурна:

6.2.1.хүсэлт гаргасан он, сар, өдөр;
6.2.2.мэргэжлийн нэгдсэн холбооны нэр;
6.2.3.мэргэжлийн нэгдсэн холбооны хаяг;
6.2.4.мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүдийн талаарх мэдээлэл.

6.3.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

6.3.1.мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах тухай шийдвэр, хурлын тэмдэглэл, уг шийдвэр болон хурлын тэмдэглэлд ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурсан байна;

6.3.2.мэргэжлийн нэгдсэн холбооны бүтэн болон товчилсон нэр;
6.3.3.мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэм;
6.3.4.мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүдийн бүртгэл, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

6.3.5.энэ хуулийн 5.3.1, 5.3.2-т заасан гишүүнчлэл, зах зээл дэх үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтыг нотолсон баримт бичиг;

6.3.6.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл.

6.4.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 6.1-д заасан хугацааг хэтрүүлсэн тохиолдолд уг хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтийг энэ хуулийн 6.3-т заасан баримт бичгийн хамт Улсын дээд шүүхэд хүргүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дугаар зүйл нэмэх:

“7 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлт, баримт бичгийг нягтлан шалгах

7.1.Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор тухайн хүсэлт, хавсаргасан баримт бичгийг бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгана.

7.2.Улсын дээд шүүх энэ хуулийн 7.1-д заасан баримт бичигт зөрчил илэрсэн тохиолдолд 30 хоногийн дотор уг зөрчлийг арилгах талаар хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

7.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхдээ энэ хуулийн 6.3-т зааснаас бусад баримт бичиг шаардахыг хориглоно.

7.4.Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбооны нэрийг нягтлан шалгахдаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1.5 дахь заалт, энэ хуулийн 9.3-т заасан нэрийн санг ашиглана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 8 дугаар зүйл нэмэх:

“8 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх, бүртгэхээс татгалзах

8.1.Улсын дээд шүүх энэ хуулийн 6.1, 6.4-т заасан хугацаанд мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзах тухай шийдвэр гаргана.

8.2.Улсын дээд шүүхийн Тамгын газар энэ хуулийн 8.1-д заасан шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор хүсэлт гаргагчид бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

8.3.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхийн Тамгын газар хүсэлт гаргагчид гэрчилгээ, тамга, тэмдгийн хяналтын дугаар олгоно. Гэрчилгээ нь цахим хэлбэртэй байж болно.

8.4.Улсын дээд шүүх дараах үндэслэлээр мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхээс татгалзана:

8.4.1.мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан;

8.4.2.энэ хуулийн 9 дүгээр зүйлийг зөрчин нэр хэрэглэсэн;

8.4.3.энэ хуулийн 6.3.5-д заасан баримт бичиг шаардлага хангаагүй, эсхүл бүрдэл дутуу бол.

8.5.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбар, дэд салбар бүрд нэг хүртэл мэргэжлийн нэгдсэн холбоо байна.

8.6.Улсын дээд шүүх энэ хуулийн 8.1-д заасан шийдвэр гаргахаас өмнө хүсэлт гаргагч, улсын бүртгэлийн байгууллага болон бусад этгээдээс тайлбар авах, нэмэлт баримт бичиг, лавлагаа, мэдээлэл гаргуулах, шинжээч томилон ажиллуулж болно.

8.7.Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхтэй холбогдсон журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн энэ хууль болон бусад хуульд нийцүүлэн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 10 дугаар зүйл бүхий Гуравдугаар бүлэг нэмэх:

**“ТУРАВДУГААР БҮЛЭГ
МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГИШҮҮНЧЛЭЛ, ЧИГ ҮҮРЭГ**

10 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, зохион байгуулалт

10.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо ерөнхийлөгч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гишүүдээс бүрдэнэ.

10.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгчийн бүрэн эрх, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний эрх зүйн байдал, гишүүдийн эрх, үүрэг, бүх гишүүдийн хурлыг зохион байгуулах, саналын эрхийг тогтоох, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдсон бусад харилцааг мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмээр тогтооно.

10.3.Мэргэжлийн нэгдсэн холбоо мэргэжлийн ангиллаар дагнасан хороотой байж болно.

10.4.Мэргэжлийн нэгдсэн холбоо орон нутаг болон гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээж болно.

10.5.Мэргэжлийн нэгдсэн холбооны санхүүжилт нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

10.6.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь өөрийн нэр дээр банкны данстай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11 дүгээр зүйл болгох:

“11 дүгээр зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнчлэл

11.1.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнчлэл нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбар, дэд салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодоос бүрдэнэ.

11.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнчлэлийн тоонд хязгаар тогтоохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12 дугаар зүйл болгох:

“12 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүрэг

12.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.1.1.гишүүн мэргэжлийн холбоодыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, салбарын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

12.1.2.тухайн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах;

12.1.3.тухайн салбарын хэрэгжүүлэх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, түүнийг олон нийтэд сурталчлах ажиллагаанд гишүүдээ төлөөлөн оролцох, хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

12.1.4.төрийн байгууллагын зарим чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

12.1.5. гишүүн мэргэжлийн холбооны өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд төрийн аль ч шатны байгууллагад төлөөлөх, өөрийн байр сууриа илэрхийлэх;

12.1.6. тухайн салбарт өндөр технологи, инновацийг хөгжүүлэх, бараа, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

12.1.7. салбарын үйлдвэрлэлийн явц, технологийн түвшинг тогтоох, үнэлэх, борлуулалтын зах зээл, бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварт мэргэжлийн үнэлгээ, дүгнэлт өгөх;

12.1.8. салбарын хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэргэшил дээшлүүлэх сургалт зохион байгуулах;

12.1.9. мэргэжлийн үйл ажиллагааны стандарт боловсруулах, нутагшуулахад хамтран ажиллах, хэрэглээний тайлбар зөвлөмж бэлтгэх;

12.1.10. мэргэжлийн нэгдсэн холбооны баримтлах мэргэжлийн болон ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

12.1.11. гишүүн мэргэжлийн холбоодыг төлөөлөн гадаад болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

12.1.12. санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах, бүх гишүүддээ тайлагнах, аудит хийлгэх, олон нийтэд ил тод, нээлттэй байршуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

15. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 13 дугаар зүйл болгох:

“13 дугаар зүйл.Төрийн байгууллагатай хамтран ажиллах

13.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо төрийн байгууллагатай дараах чиглэлээр хамтран ажиллана:

13.1.1.тухайн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, стандарт, шийдвэрийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий зөвлөл, хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, санал, зөвлөмж гаргах;

13.1.2.зөвшөөрөл шинээр бий болгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг өөрчилж дүгнэлт гаргахад санал өгөх, шаардлагатай тохиолдолд тухайн зөвшөөрлийн хэрэгцээ, шаардлага, эрсдэлийн түвшин, үнэлгээний талаар санал, дүгнэлт гаргах;

13.1.3.хуульд заасан тохиолдолд зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасны дагуу шилжүүлэн авах;

13.1.4.тухайн салбарын техникийн нөхцөл, стандартыг боловсруулах, батлах, мөрдүүлэх, хэрэглээний тайлбар, зөвлөмж бэлтгэх;

13.1.5.хуульд заасан тохиолдолд төрийн байгууллагын зарим чиг үүргийг хууль, гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

13.1.6.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцох, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах;

13.1.7.салбарын хүний нөөцийн бодлогыг тодорхойлоход мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтаар суралцагчид эзэмшүүлэх мэргэшлийн түвшинг Хөдөлмөрийн тухай хуулийн 17.2, 17.3-г зааснаар тодорхойлоход оролцох;

13.1.8.хууль болон мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэмд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “этгээдэд” гэсний дараа “Эрүүгийн хууль, эсхүл” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 14.1 дэх хэсгийг тус тус нэмэх:

“14.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.1 дэх хэсэг болгох:

“15.1.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 45 минут үргэлжилж, 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 11 цаг 46 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Улсын Их Хурлын даргын
уулзалт, хурлын” танхим
11 цаг 01 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Цэрэнпунцаг: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Ингээд хуралдаанд оролцож байгаа гишүүдийнхээ нэрсийг танилцуулъя. Цэрэнпунцаг ирсэн, Баттөмөр гишүүн ирсэн, Ганбаатар гишүүн ирсэн, Ганхуяг гишүүн ирсэн. Жавхлан гишүүн ирсэн, Оюунчимэг гишүүн ирсэн, Ундрам гишүүн ирсэн, Чинзориг гишүүн ирсэн. Б.Энхбаяр гишүүн ирсэн, Энхтүвшин гишүүн ирсэн. Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 60 хувьтай бүрэлдсэн тул өнөөдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг нарын 7 гишүүн 2024 оны 4 сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

2.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. /Ашигт малтмал хайх, ашиглах зориулалттай газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ноогдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагааг хяналт шалгалт хийх үүрэг бүхий Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг нарын 30 гишүүн 2024 оны 4 сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

3.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /УлсынИх Хурлын гишүүн Учрал 2019 оны 2 сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ гэсэн эдгээр 3 асуудлыг Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудлуудад оруулж шийдвэрлэсэн.

Өнөөдөр гэж байгаа 2024 оны 4 сарын 11-ний өдөр байгаа.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье ээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүд нэрсээ өгнө үү. Энхтүвшин гишүүн асуулттай байна. Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Хянан шалгах түр хороо гээд байгуулчихсан байна л даа. Энэ чинь нөгөө Газрын тухай хуулиар энэ эдэлбэр газар чинь бол сум, орон нутгийн удирлага шийдээд явж байгаа. Ашигт малтмалын газар бол юу гэдэг юм Ашигт малтмалын тухай хуулиараа явж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Энхтүвшин гишүүн ээ, энэ 2 дахь асуудал байгаа. Энэ чинь эхнийх. Та тэр 2 дахь асуудлаа хэлэлцэхэд хэлчих үү.

Ингээд гишүүд алга байна. Хэлэлцэх асуудлын нэгтэй холбоотой асуулт асуух гишүүд алга байна. Ингээд хуулийн төслийн талаар Байнгын

хорооны хуралдаанд оролцсон гишүүдээс санал гараагүй байна. Би нэг горимын саналтай байна.

Энэ Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсгийг үндэслэн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулахыг дэмжье гэсэн горимын санал гаргаж байгаа юм.

С.Чинзориг: Хэлэлцэх эсэх нь орсон юм уу.

Ц.Цэрэнпунцаг: Орсон. Энэ горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Тэгвэл яах вэ энийгээ протокол дээр тусгачихъя тэгэх үү. Эхлээд явуулчих уу. Эхлээд нөгөө горимын санал гаргая. Өнөөдөр ингээд техникийн боломжгүй саяын санал хураалтыг хүчингүй болгочихъя 1 дүгээрт. Санал хураалт. Ингээд гишүүдийн олонх дэмжиж байна. Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалтыг Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Мөн Баттөмөр гишүүн дэмжсэн. Ундрам гишүүн дэмжсэн. Оюунчимэг гишүүн дэмжсэн. Ингээд гишүүдийн олонх дэмжсэний тулд саяын хураасан санал хураалт хүчингүй боллоо.

Ингээд горимын санал гаргая. Өнөөдөр техникийн саатал үүссэн байгаа учраас өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дээр санал хураалтыг гараар явуулъя гэсэн горимын санал гаргаж байна. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Баттөмөр гишүүн дэмжиж байгаа.

Ундрам гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ингээд гишүүдийн олонх дэмжсэн тул өнөөдрийн хуралдааны санал хураалтыг гараар явуулна.

Дахин 1 горимын санал байна. Өнөөдрийн хэлэлцэх 1 дүгээр асуудалтай холбоотой горимын саналын томъёоллын уншиж танилцуулъя.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсгийг үндэслэн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Горимын санал хураалт. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрам гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Гишүүдийн олонх дэмжсэн тул санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ танилцуулна.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

11.07 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 2.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Хянан шалгах түр хороо байгуулах тухай.

Хуулийн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгосон, зохих төлбөр давхар ногдуулсан, хураасан эсэхийг шалгах шаардлагыг харгалзан Монгол Улсын Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт, 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны шалгалтын сэдвийг ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр тогтоосугай.

2. Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай.

1/Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох үйл ажиллагаа;

2/Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийг бүртгэх үйл ажиллагаа;

3/Тусгай зөвшөөрөл олгосон газар, түүний хэвлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх;

4/Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид төлбөр, татвар ноогдуулах, тайлагнах, төлөх, хянах, хураах үйл ажиллагаа.

3. Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Олонхыг төлөөлж:

Ц.Цэрэнпунцаг Улсын Их Хурлын гишүүн

Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын гишүүн

Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын гишүүн

Цөөнхийг төлөөлж:

Ш.Адъяа Улсын Их Хурлын гишүүн

Т.Доржханд Улсын Их Хурлын гишүүн.

4. Хяналт шалгалтын тайлан, санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулахыг Хянан шалгах түр хороонд даалгасугай.

5. Энэ тогтоолыг 2024 оны 4 дүгээр сарын ... энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Та бүхэнд тогтоолын төслийг уншиж танилцууллаа. Ингээд тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нээрээ өгнө үү. Асуулт үг хамт байгаа. Энхтүвшин гишүүн асуулт асууж, үгээ хэлье.

Т.Энхтүвшин: Энэ ингээд газартай холбоотой ашигт малтмал эрж хайх, ашиглах, түүний хэвлийн тусгай зөвшөөрлийн төлбөр ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийнэ гээд орчихсон байна л даа. Энэ удирдамжийг уншаад байхаар ерөөсөө энэ ашигт малтмалтай холбоотой, газрын хэвлийн баялагтай холбоотой энэ газрыг шалгахгаар байгаа байхгүй юу. Шалгахгаар. Энэ доторхыг нь

унишихаар нөгөө сумын Засаг дарга олж байгаа тусгай хамгаалалттай газар нутгийг тусгай хамгаалалтад авах, аж ахуйн зориулалтаар олгож байгаа Монгол Улсын иргэнд газар өмчлүүлж байгаа гээд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга олгож байгаа энэ газрыг бас давхар шалгахгаар энэ үг үсэг нь байгаад байгаа байхгүй юу.

Хэрвээ ийм 2 шалгалт явуулах гэж байгаа бол тус тусд нь ажлын хэсэг байгуулахгүй бол болохгүй. Нэгдүгээрт энэ Ашигт малтмал, газрын тосны эрхлэх газраас хайгуулын болон хайгуулын лицензийн газрыг өгч байгаа шүү дээ. Газрын тухай хуулиар бол аж ахуйн зориулалттай эдэлбэр газар болон өмчлөлийн газрыг олгож байгаа асуудал байгаа байхгүй юу даа. Энийг бол үзээд байхад Газрын тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулиар олгосон газрын ашиглалтыг оногдуулж байгаа төлбөр, татвар хураамжийг шалгана гээд энэ нэг зааг ялгааг нь гаргахгүй бол ингээд хараад байхад яг ашигт малтмалыг нь шалгах гээд байгаа юм уу, нөгөө аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын олгож байгаа эдэлбэр газрыг нь шалгах гээд байгаа юм уу гэдэг юмнуудын нарийн зааг ялгааг нь гаргаж өгөхгүй бол энэ сум, дүүргийн Засаг даргын олгож байгаа энэ эдэлбэр газрыг шалгах юм бол энэ бол маш их өргөн хүрээтэй ийм асуудал болно. Тийм учраас энийгээ бас нэг нарийвчлаад яг ашигт малтмалаас олгож байгаа тэр хайгуулын болон ашиглалтын лицензүүдийн газрыг шалгах уу. Яг одоо сум, дүүргийн Засаг даргын олгож байгаа эдэлбэр газрыг шалгах уу гэдэг энэ зааг ялгааг нь хийж өгөхгүй бол яг үүгээр бол хоёуланг нь шалгахгаар орчихсон байна л даа.

Тухайлбал одоо юу гэдэг юм. Энэ ашигт малтмалын лиценз болон юу гэдэг юм хайгуулын лиценз 9 жилийн хугацаатай өгч байгаа. Хайгуулаа хийгээд, эрдэс баялагийн зөвлөлөөр ороод А лиценз болчих юм бол хугацаагүй болж байна. Эдэлбэр газар бол 100 жил хүртэл

хугацаагаар гэж байгаа. Сум, дүүргийн Засаг даргын олгож байгаа газар бол 15 жил, 40 жил, тэгээд 60 жил гээд. Тэгэхээр энэ юмнуудаа ингэж зааг ялгааг нь гаргахгүй бол нөгөө сум, дүүргийн Засаг даргын олгож байгаа газрыг шалгах юм бол энэ бол.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Би хариулъя. Та асуултаа асууж болсон уу. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Энэ Их Хурлын даргын захирамжаар энэ Хянан шалгах түр хороо байгуулах бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд ажлын хэсэг гаргаж, Их Хурлаас ажилласан. Байнгын хороодын дарга нар ороод, би энийг ахалж ажилласан юм. Эхний хянан шалгаж явуулах ажлын цар хүрээ бол ийм том өргөн, таны саяын дурдсан шиг ийм өргөн байсан юм. Газар олголт тэгээд л одоо олон төрлийн зориулалтаар ашиглаж байгаа, ер нь ингээд цаашилах юм бол яг таны дурдаж байгаа шиг бүх аймаг, сум, нийт 365, 70 хэдэн субъект газар олгодог. Тэр бүгдтэй холбоотой ажлыг шалгах том цар хүрээндээсээ ингээд хумигдаад, ажлын хэсэг гараад өнөөдөр энэ жил бол нэг чуулганы ажиллах энэ хугацаанд бол энэ хянан шалгах үйл ажиллагаа явахад бол нүсэр байна. 2 хянан шалгах түр хороо байгуулах нь зүйтэй юм гээд ажлын хэсгээс санал, дүгнэлт гарсан. Эхний нэг ажлын хэсэг нь бол яг энэ газрыг эдэлбэр талаас нь олгож байгаа, зөвшөөрөл олгосон, үүнтэй ашиглалттай холбоотой асуудлыг хянан шалгах нэг түр хороо.

Ашигт малтмал талаас нь ашиглаж байгаа лиценз, бид нарын ярьдгаар бол уул уурхай, ашигт малтмалын лицензтэй холбоотой асуудлыг хянан шалгах үйл ажиллагаа явуулах бас нэг хянан шалгах түр хороо байгуулъя гээд ингээд дүгнэлт гарсан. Дүгнэлтээ Улсын Их Хурлын даргад танилцуулсан. Тэгээд эндээс нэг зүйл яг энэ цаг тухайн үед нь гарч ирсэн асуудал

бол Улаанбаатар хот дахиад энэ газар олголттой холбоотой ийм ажлын хэсэг гаргачихсан нэлээн шаргуу ажиллаж байгаа юм байна лээ. Тэгэхээр зэрэг бол энэ ажлын хэсэг 1 дүгээрт ингээд давхиуулж гаргах шаардлага алга байна. Энэ ажлын хэсэг ажиллаад, санал, дүгнэлтээ танилцуулаад, дүгнэлт гаргасны дараа нь дараагийн 2 дахь эхний 2 хянан шалгах түр хорооны газрын эдэлбэр газар, газар ашиглахтай холбоотой хянан шалгах ажлын хүрээнд Хянан шалгах түр хороо байгуулах ажлыг бол энэ удаа хойш нь тавиад, ганц Хянан шалгах түр хороо байгуулъя. Энэ нь бол уур уурхайн зориулалтаар би танд сая уншиж танилцуулсан.

Энэ шалгах хүрээ хязгаарыг тогтоохдоо ингээд 4 зүйлийг дурдаад, энэ 4 чиглэлээр хянан шалгах үйл ажиллагааныхаа цар хүрээг тогтооё гээд 1 дүгээрт нь ашигт малтмал хайн ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох үйл ажиллагаа, 2-т ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийг бүртгэх үйл ажиллагаа, 3-д тусгай зөвшөөрлөөр олгосон газар, түүний хэвлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх, 4-д нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч төлбөр, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянах, хураах үйл ажиллагаа гээд ерөнхийдөө энэ АМНАТ-тай холбоотой энэ ажлын хүрээг маш тодорхой болгоод ингээд заачихсан юм. Тэгэхээр бол яг таны саяын гаргасан санал, санаа зовж байгаа дэндүү өргөн цар хүрээтэй гэж байгаа ажлыг бол ингээд цэгцлээд ийм товч тодорхой, цомхон болгосон. Тэгээд ямар ч байсан хаврын чуулганыг хаахаас өмнө бид нар Их Хуралд тайлангаа тавих ёстой гээд 5 гишүүнтэй цомхон ирцээ бодоод ингээд цөөнхийн төлөөлөл 2 намаас Ардчилсан намын бүлгийн даргатай нь зөвшилцөж албан ёсоор бичгээр оруулах гишүүний нэрийг нь авсан. Энэ нь Адышаа гишүүн. Доржханд гишүүнтэй ярьж ХҮН намаас Доржханд гишүүн өөрөө орж ажиллана гэсэн.

Тэгээд ийм ажлын хэсэг байгуулах ийм санал оруулж ирж байгаа юм.

Энхтүвшин гишүүн нэмэлт асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Би нэг үг хэлчихье. Тэгвэл таны энэ танилцуулга дээр иргэн, аж ахуйн нэгж байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэхтэй асуудал гэж байгаа байхгүй юу. Тэгээд өмчлүүлэхтэй холбоотой асуудлыг ерөөсөө л сумын Засаг дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга л гаргадаг байхгүй юу. Тэгэхээр энэ өмчлүүлэх гэдэг үгээ хасаж ярихгүй бол ямар хайгуулын лиценз юм уу, ашиглалтын лицензийг өмчлүүлнэ гэж бол байхгүй шүү дээ. Тэгэхээр таны энэ гаргасан тайлан дээр бол аж ахуйн нэгж байгууллагуудад эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэхтэй асуудал нээлттэй ил тод бус, хүртээмжгүй байхтай холбогдуулан Газрын тухай хууль болон Ашигт малтмал тухай хууль тогтоомжийн хэрэгжилт энэ зүйл дээр ажлын хэсэг байгуулж, санал, дүгнэлт гаргана л гэсэн үг зүгээр энэ танилцуулга нь дээр шүү.

Ц.Цэрэнпунцаг: Энхтүвшин гишүүн асуулт асууж дууслаа. Би товчхон хариулчихъя.

Яг таны саяын уншиж байгаа та нөгөө төсөл дээр явж байсан танилцуулгыг уншаад байгаа. Ажлын хэсгийн тайланг та уншаад байгаа юм байна. Тийм ээ. Тэгээд тэндээс гарангуутаа саяын энэ яг одоо орж ирж байгаа, өнөөдөр та бүхнээр хэлэлцүүлэх гэж байгаа энэ төсөл дээр бол яг наад асуудал чинь бол байхгүй. Яг тодорхой миний саяын 4 уншсан хүрээ хязгаар байна шүү дээ. Энэ дотор явж байгаа таны яг саяын дурдаад байгаа бол энд байхгүй. Засаж орж ирсэн. Ажлын хэсгийн танилцуулга бол маш өргөн цар хүрээтэй байгаа шүү дээ. Ийм учраас одоо энийгээ бас жоохон цэгцэлье гээд 2 тодорхой хүрээ хязгаарыг нь маш нарийн сайн тогтоож өгье л гэсэн юм. Тэгээд энэ бол ерөнхийдөө бас энэ хүрээ хязгаар

мөртөө одоо Хянан шалгах түр хороо ажиллахдаа энэ хүрээ хязгаар бол гарч болохгүй хүрээ хязгаараа тавьчихаад байгаа юм. Энийг заавал бүгдийг нь гүйцээх биш, үүнээсээ аль болохоор дотогшиоо хумьж тодорхой асуудлууд дээрээ ярихгүй бол цаг хугацааны хувьд, хүн нөөцийн хувьд байг гэхэд ажлын хэсэг хянан шалгах түр хорооны ирцийн хувьд ч гэсэн хүндрэл гарна гэж олон талаас нь харж, нэлээн тодорхой болгож, цаг хугацаандаа амжих ёстой гэдгийг хамгийн гол шалгуур үзүүлэлт болгож оруулж ирж байгаа юм шүү.

Ингээд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулж эхэллээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Ингээд Баттөмөр гишүүн дэмжиж байна. Ундрам гишүүн дэмжиж байна. Ингээд гишүүдийн дийлэнх олонх дэмжиж санал дэмжигдлээ. Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг танилцуулна.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

11.20 цаг.

3 дахь асуудалдаа оръё. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэллээ.

Ажлын хэсгийг оруулаарай. Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Оюунчимэг гишүүн уншиж танилцуулна аа. Оюунчимэг гишүүн танилцуулгаа эхэллээ.

М.Оюунчимэг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Учралаас 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 49 дүгээр захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Учралаас өргөн мэдүүлсэн Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил, Мөнхцэцэг, Пүрэвдорж, Энхболд нар ажиллалаа.

Ажлын хэсгийн хуралдаанаар хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй 22 саналын томъёолол, хамт

өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх 3 саналын томъёоллыг хэлэлцэн санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжлээ.

Мэргэжлийн нэгдсэн холбоог байгуулах, түүнд тавигдах шаардлага, үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тодорхойлох төрийн байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна. Ажлын хэсэг хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд дараах зохицуулалтыг нэмж тусгалаа.

Үүнд:

1.Хуулийн үйлчлэх хүрээг өөрчилж, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилалд хамаарах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн нэгдсэн холбоог энэ хуулиар зохицуулах бөгөөд энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Төрийн бус байгууллагын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулахаар төсөлд тусгалаа.

2.Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 34 хуулиар мэргэжлийн холбооны үйл ажиллагааг зохицуулж байгаа бөгөөд эдгээр хуулиудад мэргэжлийн холбооны ажиллах чиг үүргийг тодорхойлсон. Төсөлд мэргэжлийн холбоо гэж салбар эсвэл мэргэжлийн эрх ашгийг хамгаалах зорилгоор аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага тухайн салбарын мэргэжилтнээс бүрдэж байгуулагдсан холбоог, харин Мэргэжлийн нэгдсэн холбоо нь мэргэжлийн холбооноос бүрдсэн гишүүнчлэл бүхий холбоо байхаар тус тус тодорхойллоо.

3.Төсөлд мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах, түүнд тавигдах шаардлагыг тусгаж, мэргэжлийн нэгдсэн холбоо нь тухайн

салбарын мэргэжлийн холбоодын олонхоос бүрдэх бөгөөд тухайн салбарын зах зээл дэх үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтын 50-аас дээш хувийг эзэлдэг мэргэжлийн холбоод байхаар төсөлд тусгасан болно. Хэрвээ мэргэжлийн холбоо тухайн салбарын олонхын төлөөлөл бүхий гишүүнчлэлтэй бол энэ хуульд нийцүүлэн Мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүргийг хэрэгжүүлэхээр төсөлд тусгасан.

Мэргэжлийн нэгдсэн холбоо үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын Дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлт хүргүүлэх бөгөөд баримт бичгийг нягтлан шалгах, уг холбоог бүртгэх, бүртгэхээс татгалзах нөхцөл шаардлагыг хуулийн төсөлд шинээр нэмж тусгалаа.

5.Хуулийн төсөлд Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, зохион байгуулалт, гишүүнчлэл, чиг үүрэг, төрийн байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг тодорхойлж өглөө.

Хуулийн төсөл батлагдсанаар салбарын мэргэжлийн холбоодын эвлэлдэн нэгдэх, хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах салбарын хүрээнд хэрэгжүүлэх бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, хэлэлцэх, хэрэгжүүлэх, хяналт тавих, хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулахад мэргэжлийн нэгдсэн холбоодын төлөөллийг оролцуулах, төрийн байгууллагын зарим чиг үүргийг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх, төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг сайжруулах, улсын төсвийн ачааллыг багасгах боломж бүрдэнэ ээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрөөтэй саналын

томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Тэнгис Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Сүрэнхорол Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга, Даваабаяр “Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо”-ны Ерөнхийлөгч, Ганбаатар “Ажил олгогчдын нэгдсэн холбоо”-ны Гүйцэтгэх захирал. Хамгийн 2 идэвхтэй ажлын хэсгийнхэн чинь хааччихсан юм бэ.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэллээ. 25 Зарчмын зөрөөтэй санал байна.

Энэ анхдагч хууль тэгээд шинээр 2, 3 удаа дахиж бичих шиг болсон шүү энэ ажлын хэсгийнхэн.

Энэ дээр Мөнх-Оргил гишүүн, Баттөмөр гишүүн эд нар нэлээн идэвхтэй сайхан ажиллаж гаргасан. Ингээд та бүхэнд зарчмын зөрүүтэй саналуудыг нь томъёоллыг уншаад тус бүрд нь санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, түүнд тавигдах шаардлага, мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тодорхойлох, төрийн байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон

харилцааг зохицуулахад оршино.” Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Н.Энхболд цаашид ажлын хэсэг гэх. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундррам гишүүн дэмжлээ. Гишүүдийн олонх дэмжсэн тул санал дэмжигдлээ.

2. Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбарын мэргэжлийн нэгдсэн холбоонд энэ хууль үйлчилнэ.

3.2.Мэргэжлийн холбоо болон энэ хуулийн 3.1-д зааснаас бусад салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой харилцааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулна.

3.3.Энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Төрийн бус байгууллагын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Ундррам гишүүн дэмжлээ. Баттөмөр гишүүн дэмжлээ. Гишүүдийн олонх дэмжсэн тул 2 дахь санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.1.“мэргэжлийн холбоо” гэж салбар, эсхүл мэргэжлийн

эрх ашгийг хамгаалах зорилгоор аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, тухайн салбарын мэргэшсэн хүнээс бүрдсэн гишүүнчлэл бүхий холбоог;

4.1.2. “мэргэжлийн нэгдсэн холбоо” гэж тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодын гишүүнчлэлтэй, салбарын нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилго бүхий холбоог.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжлээ. Ундрам гишүүн дэмжлээ. Баттөмөр гишүүн дэмжлээ. 3 дахь зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

4.Төслийн Хоёрдугаар бүлгийн гарчгийн “Мэргэжлийн нэгдсэн холбооны тогтолцоо, зохион байгуулалт, чиг үүрэг” гэснийг “Мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, түүнд тавигдах шаардлага” гэж өөрчилж, 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах, түүнд тавигдах шаардлага

5.1.Мэргэжлийн нэгдсэн холбоог тухайн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоод хамтран үүсгэн байгуулна.

5.2.Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

5.2.1.мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмийг батлах;

5.2.2.мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох;

5.2.3.мэргэжлийн нэгдсэн холбооны нэрийг батлах;

5.2.4.мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулсан тухай шийдвэрийг батлах.

5.3.Мэргэжлийн нэгдсэн холбоо дараах шаардлагыг хангасан байна:

5.3.1.тухайн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодын олонхын төлөөлөл бүхий гишүүнчлэлтэй байх;

5.3.2.энэ хуулийн 5.3.1-д заасан гишүүд нь тухайн салбарын зах зээл дэх үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтын тавиас дээш хувийг эзэлдэг байх.

5.4.Тухайн салбарын мэргэжлийн холбоо дангаар, эсхүл олонхын төлөөлөл бүхий гишүүнчлэлтэй бол энэ хуульд заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн бүртгүүлж, мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүргийг хэрэгжүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжигж байна. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрам гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.

5. Төсөлд доор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмэх:

“6 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлт

6.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо үүсгэн байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.

6.2.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтийг Улсын дээд шүүхийн баталсан маягтын дагуу гаргаж, дараах мэдээллийг тусгах бөгөөд уг холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурна:

6.2.1.хүсэлт гаргасан он, сар, өдөр;

6.2.2.мэргэжлийн нэгдсэн холбооны нэр;

6.2.3.мэргэжлийн нэгдсэн холбооны хаяг;

6.2.4.мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүдийн талаарх мэдээлэл.

6.3.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

6.3.1.мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулах тухай шийдвэр, хурлын тэмдэглэл, уг шийдвэр болон хурлын тэмдэглэлд ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурсан байна;

6.3.2.мэргэжлийн нэгдсэн холбооны бүтэн болон товчилсон нэр;

6.3.3.мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэм;

6.3.4.мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүдийн бүртгэл, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг;

6.3.5.энэ хуулийн 5.3.1, 5.3.2-т заасан гишүүнчлэл, зах зээл дэх үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтыг нотолсон баримт бичиг;

6.3.6.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл.

6.4.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 6.1-д заасан хугацааг хэтрүүлсэн тохиолдолд уг хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтийг энэ хуулийн 6.3-т заасан баримт бичгийн хамт Улсын дээд шүүхэд хүргүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрэм

гишүүн дэмжлээ. Гишүүдийн олонх дэмжсэн тул санал дэмжигдлээ.

6.Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дугаар зүйл нэмэх:

“7 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлт, баримт бичгийг нягтлан шалгах

7.1.Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор тухайн хүсэлт, хавсаргасан баримт бичгийг бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгана.

7.2.Улсын дээд шүүх энэ хуулийн 7.1-д заасан баримт бичигт зөрчил илэрсэн тохиолдолд 30 хоногийн дотор уг зөрчлийг арилгах талаар хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

7.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхдээ энэ хуулийн 6.3-т зааснаас бусад баримт бичиг шаардахыг хориглоно.

7.4.Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбооны нэрийг нягтлан шалгахдаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1.5 дахь заалт, энэ хуулийн 9.3-т заасан нэрийн санг ашиглана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжлээ. Ундрэм гишүүн дэмжлээ. Баттөмөр гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.

7.Төсөлд доор дурдсан агуулгатай 8 дугаар зүйл нэмэх:

“8 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх, бүртгэхээс татгалзах

8.1. Улсын дээд шүүх энэ хуулийн 6.1, 6.4-т заасан хугацаанд мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзах тухай шийдвэр гаргана.

8.2. Улсын дээд шүүхийн Тамгын газар энэ хуулийн 8.1-д заасан шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор хүсэлт гаргагчид бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

8.3. Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхийн Тамгын газар хүсэлт гаргагчид гэрчилгээ, тамга, тэмдгийн хяналтын дугаар олгоно. Гэрчилгээ нь цахим хэлбэртэй байж болно.

8.4. Улсын дээд шүүх дараах үндэслэлээр мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхээс татгалзана:

8.4.1. мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан;

8.4.2. энэ хуулийн 9 дүгээр зүйлийг зөрчин нэр хэрэглэсэн;

8.4.3. энэ хуулийн 6.3.5-д заасан баримт бичиг шаардлага хангаагүй, эсхүл бүрдэл дутуу бол.

8.5. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбар, дэд салбар бүрд нэг хүртэл мэргэжлийн нэгдсэн холбоо байна.

8.6. Улсын дээд шүүх энэ хуулийн 8.1-д заасан шийдвэр гаргахаас өмнө хүсэлт гаргагч, улсын бүртгэлийн байгууллага болон бусад этгээдээс тайлбар авах, нэмэлт баримт бичиг, лавлагаа, мэдээлэл гаргуулах, шинжээч томилон ажиллуулж болно.

8.7. Улсын дээд шүүх мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхтэй холбогдсон журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн энэ хууль болон бусад хуульд нийцүүлэн батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Ундрам гишүүн дэмжлээ. Баттөмөр гишүүн дэмжлээ. Гишүүдийн олонх дэмжсэн тул санал дэмжигдлээ.

8. Төсөлд доор дурдсан агуулгатай 10 дугаар зүйл бүхий Гуравдугаар бүлэг нэмэх:

**“ГУРАВДУГААР БҮЛЭГ
МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН
ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГИШҮҮНЧЛЭЛ, ЧИГ ҮҮРЭГ**

10 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, зохион байгуулалт

10.1. Мэргэжлийн нэгдсэн холбоо ерөнхийлөгч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гишүүдээс бүрдэнэ.

10.2. Мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгчийн бүрэн эрх, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний эрх зүйн байдал, гишүүдийн эрх, үүрэг, бүх гишүүдийн хурлыг зохион байгуулах, саналын эрхийг тогтоох, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдсон бусад харилцааг мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмээр тогтооно.

10.3. Мэргэжлийн нэгдсэн холбоо мэргэжлийн ангиллаар дагнасан хороотой байж болно.

10.4.Мэргэжлийн нэгдсэн холбоо орон нутаг болон гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээж болно.

10.5.Мэргэжлийн нэгдсэн холбооны санхүүжилт нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

10.6.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь өөрийн нэр дээр банкны данстай байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Ундрэм гишүүн дэмжлээ. Баттөмөр гишүүн дэмжлээ.

9.Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11 дүгээр зүйл болгох:

“11 дүгээр зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнчлэл

11.1.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнчлэл нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбар, дэд салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэжлийн холбоодоос бүрдэнэ.

11.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнчлэлийн тоонд хязгаар тогтоохгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжлээ. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрэм гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.

10.Төслийн 8 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ.

Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Ундрэм гишүүн дэмжлээ. Баттөмөр гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.

11.Төслийн 9 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Ундрэм гишүүн дэмжлээ. Баттөмөр гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.

12.Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12 дугаар зүйл болгох:

“12 дугаар зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүрэг

12.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.1.1.гишүүн мэргэжлийн холбоодыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, салбарын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

12.1.2.тухайн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах;

12.1.3.тухайн салбарын хэрэгжүүлэх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, түүнийг олон нийтэд сурталчлах ажиллагаанд гишүүдээ төлөөлөн оролцох, хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

12.1.4.төрийн байгууллагын зарим чиг үүргийг хууль болон гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

12.1.5.гишүүн мэргэжлийн холбооны өмнө тулгамдсан асуудлыг

шийдвэрлэхэд төрийн аль ч шатны байгууллагад төлөөлөх, өөрийн байр сууриа илэрхийлэх;

12.1.6. тухайн салбарт өндөр технологи, инновацийг хөгжүүлэх, бараа, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

12.1.7. салбарын үйлдвэрлэлийн явц, технологийн түвшинг тогтоох, үнэлэх, борлуулалтын зах зээл, бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварт мэргэжлийн үнэлгээ, дүгнэлт өгөх;

12.1.8. салбарын хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэргэшил дээшлүүлэх сургалт зохион байгуулах;

12.1.9. мэргэжлийн үйл ажиллагааны стандарт боловсруулах, нутагшуулахад хамтран ажиллах, хэрэглээний тайлбар зөвлөмж бэлтгэх;

12.1.10. мэргэжлийн нэгдсэн холбооны баримтлах мэргэжлийн болон ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

12.1.11. гишүүн мэргэжлийн холбоодыг төлөөлөн гадаад болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

12.1.12. санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах, бүх гишүүддээ тайлагнах, аудит хийлгэх, олон нийтэд ил тод, нээлттэй байриуулах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Ундрэм гишүүн дэмжлээ. Баттөмөр гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.

13. Төслийн 11 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжлээ. Ундрэм гишүүн дэмжлээ. Баттөмөр гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.

14. Төслийн 12 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрэм гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.

15. Төслийн 13 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрэм гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.

16. Төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 13 дугаар зүйл болгох:

“13 дугаар зүйл. Төрийн байгууллагатай хамтран ажиллах

13.1. Мэргэжлийн нэгдсэн холбоо төрийн байгууллагатай дараах чиглэлээр хамтран ажиллана:

13.1.1. тухайн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, стандарт, шийдвэрийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий зөвлөл, хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, санал, зөвлөмж гаргах;

13.1.2. зөвшөөрөл шинээр бий болгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг өөрчилж дүгнэлт гаргахад санал өгөх, шаардлагатай тохиолдолд тухайн зөвшөөрлийн хэрэгцээ,

шаардлага, эрсдэлийн түвшин, үнэлгээний талаар санал, дүгнэлт гаргах;

13.1.3.хуульд заасан тохиолдолд зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1-д заасны дагуу шилжүүлэн авах;

13.1.4.тухайн салбарын техникийн нөхцөл, стандартыг боловсруулах, батлах, мөрдүүлэх, хэрэглээний тайлбар, зөвлөмж бэлтгэх;

13.1.5.хуульд заасан тохиолдолд төрийн байгууллагын зарим чиг үүргийг хууль, гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

13.1.6.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцох, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах;

13.1.7.салбарын хүний нөөцийн бодлогыг тодорхойлоход мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтаар суралцагчид эзэмшүүлэх мэргэшлийн түвшинг Хөдөлмөрийн тухай хуулийн 17.2, 17.3-т зааснаар тодорхойлоход оролцох;

13.1.8.хууль болон мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэмд заасан бусад.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжлээ. Ундрaм гишүүн дэмжлээ. Баттөмөр гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.

17.Төслийн 15 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ, Ганбаатар гишүүн дэмжлээ. Би

дэмжлээ. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрaм гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.

18.Төслийн 16 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрaм гишүүн дэмжлээ. Гишүүдийн олонх дэмжиж, санал дэмжигдлээ.

19.Төслийн 17 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрaм гишүүн дэмжлээ. Санал дэмжигдлээ.

20.Төслийн 18 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрaм гишүүн дэмжлээ. Гишүүдийн дийлэнх олонх дэмжиж, санал дэмжигдлээ.

21.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “этгээдэд” гэсний дараа “Эрүүгийн хууль, эсхүл” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 14.1 дэх хэсгийг тус тус нэмэх:

“14.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн

дэмжлээ. Би дэмжиж байна. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрэм гишүүн дэмжлээ. Гишүүдийн олонх дэмжиж, санал дэмжигдлээ.

22. Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.1 дэх хэсэг болгох:

“15.1.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрэм гишүүн дэмжлээ. Гишүүдийн олонх дэмжиж, санал дэмжигдлээ.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай:

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, М.Энхболд /цаашид “ажлын хэсэг” гэх/ санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрэм гишүүн дэмжлээ. Гишүүдийн олонх дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг

санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрэм гишүүн дэмжлээ. Гишүүдийн дийлэнх олонх дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай:

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Чинзориг гишүүн дэмжлээ. Бат-Эрдэнэ гишүүн дэмжлээ. Энхтүвшин гишүүн дэмжлээ. Оюунчимэг гишүүн дэмжлээ. Ганбаатар гишүүн дэмжлээ. Би дэмжиж байна. Баттөмөр гишүүн дэмжлээ. Ундрэм гишүүн дэмжлээ. Гишүүдийн дийлэнх олонх дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр ирүүлсэн санал алга байна. Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, Ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр уншиж танилцуулна.

Өнөөдрийн 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн Эдийн засгийн байнгын хорооны хурал үүгээр өндөрлөж байна. Ингээд хуралдаанд идэвхтэй оролцсон Байнгын хорооны эрхэм гишүүддээ баярлалаа. Ж.Бат-Эрдэнэ гишүүн, Т.Энхтүвшин гишүүн та бүхэнд

*онцгойлон баярласнаа илэрхийлье. Хурал
дууслаа.*

11.46 цаг

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ